

“ХӨВСГӨЛ” ХК

2024 оны 10 сарын 07-ны өдөр

№ 24/06

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Хувьцаа эзэмшигчдийн шаардлагаар
хувьцаа эргүүлэн худалдаж авахыг
шаардах эрхийг хэрэгжүүлэх тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 53, 54 дүгээр зүйл, 76 дугаар зүйлийн 76.1.13, 76.1.18 дахь заалт болон “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх, хяналт тавих журам”, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ээлжит бус хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

- Хөвсгөл ХК-ийн 2024 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын 24/02, 24/03 дугаартай шийдвэрийн дагуу Хөвсгөл ХК-ийн хувьцааны тоог нэмэгдүүлж, өрийг хувьцаагаар солихоор шийдвэрлэсэнтэй холбогдуулан хувьцаа эзэмшигчид нь Компанийн тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.1.2 дахь заалтад заасны дагуу өөрийн эзэмшлийн хувьцааг эргүүлэн худалдаж авахыг компаниас шаардах эрх үүсэж буй тул эргүүлэн худалдан авах шаардлага тавьсан хувьцаа эзэмшигчдийн хувьцааг худалдан авахыг шаардах эрхийг хэрэгжүүлэхээр шийдвэрлэсүгэй.
- Хувьцааг эргүүлэн худалдаж авахыг шаардах эрхийг хэрэгжүүлэх журмыг нэгдүгээр хавсралтад зааснаар баталсугай.
- Өөрийн хувьцааг эргүүлэн худалдан авахыг компаниас шаардах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах өдрийг 2024 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр байхаар тогтоосугай.
- Энэхүү шийдвэрийн талаарх мэдэгдлийг Санхүүгийн Зохицуулах хороо болон Монголын Хөрөнгийн Биржэд 2024 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн дотор хүргүүлж, Хувьцаа эзэмшигчдэд 2024 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн дотор нийтэд зарласугай. Давтан зарыг 2024 оны 10 дугаар сарын 25-ны өдөр анх мэдээлсэн хэлбэрийн дагуу олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулсугай.
- Хувьцааг эргүүлэн худалдаж авахыг шаардах эрхээ хэрэгжүүлэх хүсэлтэй хувьцаа эзэмшигчдийн шаардлагыг хүлээн авах сүүлийн хугацааг 2024 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийг дуустал байхаар тогтоосугай.

6. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж, хувьцаа эргүүлэн худалдаж авах ажиллагааг хууль тогтоомжид заасны дагуу хэрэгжүүлэн тайлагнаж ажиллахыг Гүйцэтгэх захирал /Ч.Ганхуяг/-д даалгасугай.
7. Энэхүү тогтоолыг хувьцаа эзэмшигчдэд олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зар хүргэх журмын дагуу хүргэх, хувьцаа эзэмшигчдийн шаардах эрхийг хэрэгжүүлэх шаардлагыг хүлээн авах, тайлан, мэдээлэл хүргэн ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн нарийн бичгийн дарга /О.Нандинцэцэг/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Г.УЯНГА

Хөвсгөл ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
2024 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн 24 тоот
тогтоолын Хавсралт № 1



ХӨВСГӨЛ ХК-ИЙН ХУВЬЦААГ ЭРГҮҮЛЭН ХУДАЛДАЖ АВАХЫН ШААРДАХ ЭРХИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү журам (цаашид “Журам” гэх)-аар Хөвсгөл ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар Компанийн тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.1.1-53.1.4-д заасан асуудалд эсрэг саналтай байсан болон санал хураалтанд оролцоогүй хувьцаа эзэмшигчдийн хувьцааг компани эргүүлэн худалдан авах харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Компани нь дараах асуудлуудыг хувьцаа эзэмшигчдийн хурлаас оруулсан тохиолдолд, уг хуралд эсрэг саналтай байсан болон санал хураалтанд оролцоогүй хувьцаа эзэмшигчдийн шаардлагын дагуу хувьцаагаа эргүүлэн худалдан авах үүрэгтэй. Үүнд:
 - a. Нийлүүлэх, нэгтгэх, хуваах болон хувьцаат компанийг хязгаарлагдмал хариуцлагатай компани болгон өөрчлөх замаар компанийг өөрчлөн байгуулах;
 - b. Компани Компанийн тухай хуулийн арван нэгдүгээр бүлэгт заасны дагуу хувьцаа эзэмшигчдийн хурлаар батлах шаардлагатай их хэмжээний хэлцэл хийсэн;
 - c. Компанийн дүрэмд хувьцаа эзэмшигчдийн эрхийг хязгаарласан нэмэлт, өөрчлөлтийг оруулсан, эсхүл ийм агуулгатай компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг баталсан;
 - d. Компанийн дүрэмд заасан бусад тохилдолд;
- 1.3. Хувьцаа эзэмшигчийн нэгж хувьцааг эргүүлэн худалдаж авах үнийг нэг бүр нь 126.17 төгрөг байна.
- 1.4. Журмын дагуу өөрийн эзэмшлийн хувьцааг эргүүлэн худалдаж авахыг компаниас шаардах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг Санхүүгийн Зохицуулах Хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377 тоот тогтоолоор баталсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх, хяналт тавих журам”-ын дагуу үнэт цаас эзэмшигчдийн бүртгэлд байсан мэдээллийг үндэслэн гаргана.
- 1.5. Өөрийн эзэмшлийн хувьцааг эргүүлэн худалдаж авахыг компаниас шаардах эрхээ хэрэгжүүлэх хүсэлтэй хувьцаа эзэмшигч нь эргүүлж авах тухай шаардлагыг уг шаардах эрхийг үүссэн шийдвэр гарснаас буюу хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэр гарсан болон эрх бүхий төрийн байгууллага шийдвэр гарсан өдөр, эсхүл ийм эрх үүссэн тухай компаниас бичгээр мэдэгдэл авснаас хойш ажлын 30 өдрийн дотор компанид бичгээр гаргах бөгөөд түүнд эцэг (эх)-ийн нэр, өөрийн нэр, оршин суугаа газрын хаяг болон эргүүлэн худалдаж авахыг шаардаж байгаа хувьцааны тоо, төрлийг заана.
- 1.6. Хувьцаагаа эргүүлэн худалдан авахыг шаардсан мэдэгдлийг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Нарийн бичгийн дарга болон Гүйцэтгэх захирал хүлээн авч тухай бүр Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Аудитын хороо болон Төлөөлөн Удирдах Зөвлөлийн даргад мэдэгдэж ажиллах үүрэгтэй бөгөөд Гүйцэтгэх захирал нь хувьцаа эзэмшигчтэй “Хувьцаа эргүүлэн худалдан авах гэрээ” байгуулж, “Хувьцаа эргүүлэн худалдан авах гэрээ”-г төрийн эрх бүхий

байгууллагад хууль, тогтоомжид заасан хугацаанд бүртгүүлж хэрэгжилтийг хангаж ажиллана.

Хоёр. Бусад хувьцаа эзэмшигчийн эрх, үүрэг

- 2.1. Монгол Улсын Компанийн тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.2 дахь хэсэгт заасны дагуу бусад энгийн хувьцаа эзэмшигч хувьцаагаа эргүүлэн худалдаж авахыг шаардах эрхтэй.
- 2.2. Хувьцаа эзэмшигч нь олон нийтийн мэдээллийн хэрэгслээр цахим хэлбэрээр анх мэдэгдэл хүлээн авснаас хойш ажлын 30 хоногийн дотор буюу 2024 оны 10 дугаар сарын 11-ний өдрөөс 2024 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийг дуустал “Хөвсгөл” ХК-д өөрийн шаардлагаа бичгээр цаасан хэлбэрээр биечлэн эсвэл цахим хэлбэрээр хүргүүлнэ.
- 2.3. Компанийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.2 дахь хэсэгт заасны дагуу хувьцаагаа эргүүлэн авахыг шаардсан хувьцаа эзэмшигч нь шаардлагадаа эцэх эхийн нэр, өөрийн нэр, регистрийн дугаар, оршин суугаа хаяг, эргүүлэн авахыг шаардаж буй хувьцааны тоо, төрөл, холбоо барих утасны дугаар зэрэг хувийн мэдээллийг ирүүлэхийг зөвшөөрч хавсралтад заагдсан мэдээллийг бүрэн оруулах үүрэгтэй.
- 2.4. Хувьцаа эзэмшигч нь Компанид хувьцаа худалдах тухай шаардлагыг бичгээр гаргахдаа холбогдох мэдээллийг үнэн зөв гаргах үүрэгтэй ба шаардлагад худал мэдээлэл оруулсантай холбогдуулан гарах үр дагаврыг Компани хариуцахгүй болно.

Гурав. Компанийн эрх, үүрэг

- 3.1. Компаниас шаардах эрх үүссэн талаарх шийдвэрийг холбогдох журмын дагуу өдөр тутам хэвлэгдэн гардаг сонин, орон даяар нэвтрүүлэг хүргэдэг телевиз, Компанийн өөрийн болон Монголын Хөрөнгийн Биржийн цахим хуудсаар тус бүр 2-оос доошгүй удаагийн давтамжтайгаар олон нийтийн мэдээллийн хэрэгслээр олон нийтэд мэдээллэх үүрэгтэй.
- 3.2. Компани нь хувьцаа эзэмшигчийн хувийн мэдээллийг хамгаалж бусдад задруулахгүй байх үүрэгтэй.
- 3.3. Энэхүү Журмын 2.2 дахь хэсэгт зааснаар Компанид хүргүүлсэн хувьцаа эзэмшигчийн шаардлагыг хүлээн авч хуульд заасан хугацаанд шийдвэрлэн хариу хүргүүлэн ажиллах үүрэгтэй.

Дөрөв. Хувьцаа эзэмшигчийн шаардлагаар компани хувьцааг эргүүлэн худалдаж авахыг шаардах эрхийг хэрэгжүүлэх тухай

- 4.1. Бусад хувьцаа эзэмшигчийн хувьцаагаа эргүүлэн худалдан авах шаардах эрх нь Компанийн Хувьцаа Эзэмшигчдийн 2024 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 24/02, 24/03 дугаартай ээлжит хурлын тогтоол батлагдсан өдөр үүссэнд тооцно.
- 4.2. Компани нь хувьцаа эзэмшигчдэд Компанид хувьцаагаа эргүүлэн худалдах эрх үүссэн тухай мэдэгдлийг энэхүү журмын 3.1 дэх хэсэгт заасны дагуу хүргэнэ.
- 4.3. Компани нь энэ журмын 4.1 дэх хэсэгт заасан “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн тархалтын мэдээнд үндэслэн нэрсийн жагсаалтыг батална.
- 4.4. Өөрийн эзэмшлийн хувьцааг эргүүлэн худалдаж авахыг компаниас шаардах эрхээ хэрэгжүүлэх хүсэлтэй хувьцаа эзэмшигч нь эргүүлж авах тухай шаардлагыг энэхүү журмын нэгдүгээр хавсралтад заасан маягтын дагуу бичгээр гаргах бөгөөд Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Централ Тауэр, 17 давхар хаягт цаасан хэлбэрээр биечлэн эсхүл цахим хэлбэрээр хүргүүлнэ.

- 4.5. Хувьцаа эзэмшигч нь энэхүү журмын 2.2 дахь хэсэгт заасны дагуу ажлын 30 өдрийн дотор шаардах эрхээ хэрэгжүүлэх шаардлагыг ирүүлээгүй тохиолдолд хувьцаа эзэмшигчээр хэвээр үлдэх саналтайд тооцно.
- 4.6. Энэхүү журмын 2.2 дахь хэсэгт заасны дагуу Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс тогтоосон буюу Компанийн тухай хуулийн 54.5 дахь хэсэгт заасан хугацаанд шаардах эрхээ хэрэгжүүлээгүй буюу хүсэлт гаргаагүй хувьцаа эзэмшигч нь гомдол гаргах эрхгүй байна.
- 4.7. Компани нь хувьцаа эзэмшигчээс энэхүү журмын 4.4 дэх хэсэгт заасны дагуу хувьцаа эргүүлэн худалдаж авах шаардлагыг хүлээн авснаас хойш хувьцаа эзэмшигчийн хүсэлтийг “Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв”-рүү хүргүүлэх бөгөөд хүсэлт хүлээн авснаас хойш ажлын 30 хоногийн дотор шийдвэрлэнэ.